



Бүгд Найрамдах Хятад Ард улсын Гаалийн тухай хууль

/бүрэн эхээр/

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.

Энэ хуулийн зорилго нь улсын тусгаар тогтнол, ашиг сонирхолыг хамгаалах, Гаалийн хяналт шалгалтыг бэхжүүлэх, гадаадын улс орнуудтай эдийн засгийн асуудлаар болон, худалдаа, шинжлэх ухаан технологи, соёлын чиглэлүүдээр солилцоог дэмжих болон социалист хөгжлийг баталгаажуулах зорилгоор боловсруулагдсан болно.

2 дугаар зүйл.

БНХАУ-ын гаалийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт орж гарч буй бүхий л хүн болон бараа биет зүйлсэд / цаашид хилээр нэвтрүүлэх болон гаргаж буй хүн болон биет зүйл гэх/ хяналт шалгалт тавих эрх бүхий төрийн байгууллага болно . Гаалийн байгууллага нь энэхүү хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүн, аялагчийн ачаа, шуудан зэрэг тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтэрч байгаа болон гарч байгаа зүйлүүдийг хянаж, шалгалт явуулах бөгөөд / цаашид хилээр нэвтрүүлэх болон гаргаж буй тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүн гэх / гаалийн татвар болон бусад татвар, хураамжийг цуглуулах, хууль бусаар хилээр бараа нэвтрүүлж буй үйлдлийг илрүүлж зогсоох , хил гаалийн статистик мэдээ боловсруулах болон бусад гаалийн үйл ажиллагааг хариуцан ажиллана.

3 дугаар зүйл.

Төрийн зөвлөлөөс байгуулсан Гаалийн ерөнхий газар нь улсын бүх гаалийн байгууллагуудын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана. Төрөөс гадаадын улс орнууд, бус нутгуудад нээлттэй гаалийн байгууллагуудыг боомтууд дээр байгуулах ба Гаалийн байгууллагын хяналт, шалгалтын төвлөрсөн үйл ажиллагаа шаардлагатай газруудад байгуулна. Нэг гаалийн байгууллага нөгөөдөө харьяалагдахыг засаг захиргааны хуваариар хязгаарлагдахгүй. Гаалийн байгууллагууд нь энэхүү хуулийн дагуу чиг үүрэг, эрх мэдлээ бие даан хэрэгжүүлэх бөгөөд Гаалийн ерөнхий газрын өмнө хариуцлага хүлээнэ.

4 дүгээр зүйл.

Гаалийн байгууллага нь дараахь эрх мэдлийг хэрэгжүүлнэ:

1. Хилээр нэвтрүүлж, гаргаж буй тээврийн хэрэгслийг шалгаж, хилээр нэвтрүүлж, гаргаж буй бараа бүтээгдэхүүнүүдийг шалгах , энэхүү хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг цагдан хорих,
2. Нутаг дэвсгэрт орж, гарч буй хүний бичиг баримтуудыг шалгах; энэхүү хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэж сэжиглэгдэж буй этгээдийг байцаах болон тэдгээрийн хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах;
3. Хилээр нэвтрүүлж гаргаж буй тээврийн хэрэгсэл болон бараа бүтээгдэхүүнтэй холбоотой гэрээ хэлэлцээр, нэхэмжлэх, болон төлбөр тооцооны баримт бичиг,бүртгэл, бизнес захиа, утас болон аудио, видео бүтээгдэхүүнүүдийг шалгаж, хуулбарлан авах; нутаг дэвсгэрт орж, гарч буй тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнтэй хамааралтай, энэхүү хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг цагдан хорих,
4. Гаалийн байгууллагын ойролцоо гаалийн хяналтын бүс болон тодорхой эргийн болон хилийн бүсэд, хууль бусаар бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд оролцсонд сэжиглэгдэж буй тээврийн хэрэгсэл болон хууль бусаар хил нэвтрүүлсэн бараа бүтээгдэхүүнийг нуусанд сэжиглэгдэж буй агуулах байрнуудыг хайж илрүүлэх болон хууль бусаар хил нэвтрүүлсэнд сэжиглэгдэж буй этгээдийг хайх. Гаалийн байгууллагын захирлын зөвшөөрлийн дагуу сэжигтэй гэмт хэрэгтэн, хууль бус наймаачинг цагдан хорьж болох ба шүүх байгууллагад хүлээлгэн өгнө. Ийм цагдан хорих ажиллагаа нь 24 цагаас хэтрэхгүй ба , тусгай нөхцөлд 48 цаг хүртэл сунгаж болно.
Гаалийн байгууллагын ойролцоо тодорхой эргийн болон хилийн бүсийн хамрах хүрээг Гаалийн ерөнхий газраас Төрийн зөвлөлийн харьяа Нийтийн аюулгүй байдлын салбар болон холбогдох орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран тогтооно.
5. Гаалийн ажилтнууд нь гаалийн хяналтыг эсэргүүцсэн буюу зугтаасан этгээд, тээврийн хэрэгслийг хөөж болох ба Гаалийн байгууллагын ойролцоо гаалийн хяналтын бүс болон, тодорхой эргийн болон хилийн бүсээс гадна газруудад хяналт тавьж тэдгээрийг буцаан авчирч, зохих ёсоор зохицуулна.
6. Гаалийн байгууллага нь чиг үүргээ гүйцэтгэхдээ зэвсгээр хангагдсан байна. Гаалийн ажилтнуудын зэвсэг хэрэглэх болон авч явах дүрэм журмыг Гаалийн ерөнхий газар Төрийн зөвлөлийн харьяа Нийтийн аюулгүй байдлын салбартай хамтран тогтоох ба Төрийн зөвлөлд мэдэгдэж зөвшөөрөл авна.

5 дугаар зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнийг Гаалийн байгууллага байгаа газраар л нутаг дэвсгэрт оруулах, гаргах үйл ажиллагааг явуулна. Хэрэв онцгой нөхцөл байдал буюу урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлын улмаас Гаалийн байгууллага байхгүй газраар хил нэвтрэх бол Төрийн зөвлөлөөс буюу Төрийн зөвлөлөөс олгосон эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсан байх ёстой бөгөөд энэхүү хуулийн дагуу зохих ёсоор гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

6 дугаар зүйл.

Өөрөөр заагаагүй бол, экспорт, импортын бараа бүтээгдэхүүнүүдийг мэдүүлсэн байх ёстой ба тэдгээрийн татварыг Гаалийн байгууллагад бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүд нь буюу импорт, экспортын бизнес эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжүүд нь төлнө. Энэхүү аж ахуйн нэгжүүдийн мэдүүлэг хийх ажилтнууд нь Гаалийн байгууллагаас үнэлэгдэж, зөвшөөрөгдсөн байна. Хилээр нэвтрүүлж, гаргаж буй бараа бүтээгдэхүүний мэдүүлэг болон татвар төлөлтийн тухай гаалийн бүрдүүлэлтийг эзэмшигч нь өөрөө буюу итгэмжилсэн бие төлөөлөгч нь гүйцэтгэнэ. Мэдүүлгийн бүрдүүлэлтийг хийхээр итгэмжлэгдсэн төлөөлөгч нь уг хуулийн эзэмшигчдэд хамааралтай бүх заалтуудыг дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл.

Гаалийн байгууллагын ажилтнууд нь уг хууль, дүрмүүдийг дагаж мөрдөх буюу хууль тогтоомжийг шударгаар хэрэгжүүлж, үүргээ биелүүлж, соёлч боловсноор үйлчилгээ үзүүлнэ. Ямар ч байгууллага, хувь хүн хуулийн дагуу үзүүлж буй гаалийн үйл ажиллагаанд саад учруулж болохгүй. Гаалийн ажилтан ажил үүргээ биелүүлж байх үед эсэргүүцэлтэй тулгарвал, Нийтийн аюулгүй байдлын байгууллага болон Ардын зэвсэгт цагдаагийн байгууллага буюу холбогдох үүргийг гүйцэтгэж буй нэгжүүд нь туслалцаа үзүүлнэ.

Бүлэг 2. Хилээр нэвтрүүлж, гаргаж буй тээврийн хэрэгсэл

Гаалийн байгууллага байгаа газарт ирж байгаа болон явж байгаа тээврийн хэрэгслүүдийг, тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд нь гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлэг өгч, холбогдох бичиг баримтуудыг шалгуулахаар мэдүүлэх ба гаалийн хяналт, шалгалтыг хүлээн зөвшөөрч явуулна .

Гаалийн байгууллага байгаа газарт байрлаж байгаа хилээр нэвтрүүлж, гаргаж буй тээврийн хэрэгслүүд нь Гаалийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр явж болохгүй. Хилээр нэвтрүүлж, гаргаж буй тээврийн хэрэгсэл нь Гаалийн байгууллага байгаа нэг газраас нөгөөд хүрэхээс өмнө гаалийн хяналтын шаардлагуудыг мөрдөж, гаалийн бүрдүүлэлтийг дуусгасан байх ёстой, бөгөөд Гаалийн байгууллагатай тооцоог дуусгаагүй тээврийн хэрэгсэл нь чиглэлээ өөрчлөх болон нутаг дэвсгэрийг орхиж болохгүй.

9 дүгээр зүйл.

Хилээр орж ирж буй тээврийн хэрэгсэл нь нутаг дэвсгэрт орж ирсэн боловч Гаалийн байгууллагад мэдүүлгээ өгөөгүй буюу хилээр гарч буй тээврийн хэрэгсэл нь Гаалийн байгууллагатай тооцоогоо дуусгасан боловч нутаг дэвсгэрийг орхиогүй байгаа бол Харилцаа холбооны эрх бүхий байгууллагуудаас тодорхойлсон чиглэлээр явж болно, ийм тодорхойлсон чиглэл байхгүй бол уг чиглэлийг Гаалийн байгууллагаас тодорхойлно.

10 дугаар зүйл.

Тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд буюу холбогдох Тээвэр холбооны газраас хилээр нэвтэрч, гарч буй хөлөг онгоц, галт тэрэг болон нисэх онгоц нь хэзээ ирэх болон хэзээ хөдлөх, хаана байрлах, байрлаж буй хугацаандаа хаашаа явах болон бараа бүтээгдэхүүн, ачааг хэзээ ачих болон буулгах талаарх мэдээллийг Гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэх ёстой.

11 дүгээр зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй бараа бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгслээс буулгах болон ачих, хилээр нэвтэрч, гарч буй зорчигчдыг тээврийн хэрэгслээс буулгах болон суулгахад гаалийн хяналтыг дагаж мөрдөнө. Тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд нь ачилт, буулгалтыг дуусгасны дараа ачилт буулгалтын бодит байдлын бүртгэлийг агуулсан бичлэгүүдийг Гаалийн байгууллагад мэдүүлнэ. Хилээр нэвтэрч, гарч буй тээврийн хэрэгслээс бууж, сууж буй зорчигчид нь авч яваа эд зүйлсийнхээ талаар Гаалийн байгууллагад үнэн зөвөөр мэдүүлж, гаалийн хяналтыг дагаж мөрдөнө.

12 дугаар зүйл.

Хилээр нэвтэрч, гарч буй тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага шалгаж байх үед, уг тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд нь байлцах бөгөөд тээврийн хэрэгслийн өрөө, кабин, хаалгуудыг Гаалийн байгууллагын хүсэлтийн дагуу нээлттэй байлгана; хууль бусаар бараа нэвтрүүлэхээр завдсан гэж сэжиглэвэл, хууль бусаар хил нэвтрүүлсэн бараа, эд зүйлсийг нууж байж болзошгүй тээврийн хэрэгслийн хэсгийг нээж, салгах бөгөөд бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг устгана.

Ажлын шаардлагын дагуу, гаалийн байгууллагаас ажилтнуудыг тээврийн хэрэгсэл дээр үүрэггүйцэтгүүлэхээр илгээж болно. Тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд нь тэдний тав тухтай байдлыг хангана.

13 дугаар зүйл.

Нутаг дэвсгэрээс гаднах улсууд болон бүс нутгуудаас хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэл, нутаг дэвсгэр доторх аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын хилээр гаргаж буй тээврийн хэрэгслийг гаалийн бүрдүүлэлтийг дуусгаж, гаалийн татварыг төлөхөөс өмнө шилжүүлж, хүргэж болохгүй.

14 дүгээр зүйл.

Хилээр нэвтэрч, гарч буй хөлөг онгоц, нисэх онгоцууд нь бараа бүтээгдэхүүн болон зорчигчдыг нутаг дэвсгэрийн дотор нэгэн зэрэг тээвэрлэж байгаа тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлийг авсан байх ёстой бөгөөд гаалийн хяналтын шаардлагуудыг биелүүлсэн байна. Хилээр нэвтэрч, гарч буй тээврийн хэрэгслүүдийг нутаг дэвсгэрийн доторх тээврийн бизнес болгон өөрчлөхийг хүсвэл Гаалийн байгууллагад гаалийн бүрдүүлэлтийг дуусгаж өгсөн байх ёстой.

15 дугаар зүйл.

Далайн тусгай үйл ажиллагаа эрхэлж буй эргийн тээврийн хөлөг онгоц, загас агнуурын хөлөг онгоцнууд болон усан онгоцнууд нь гаалийн баталгаат зөвшөөрөлгүйгээр бараа бүтээгдэхүүн солилцох, худалдан авах буюу хил нэвтрүүлж, гаргаж буй бараа бүтээгдэхүүнийг шилжүүлж болохгүй.

16 дугаар зүйл.

Гэнэтийн давагдашгүй байгалийн хүчин зүйлээс шалтгаалж хилээр нэвтэрч, гарч буй хөлөг онгоц, нисэх онгоцууд нь хүчээр буух, газардах, ослын үед ачааг хаях болон гаалийн байгууллага байхгүй газарт бараа бүтээгдэхүүнийг буулгах бол тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд нь тэр даруй хамгийн ойрын гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

Бүлэг 3. Хилээр бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх, гаргах

17 дугаар зүйл.

Импортын бүх бараа бүтээгдэхүүнүүд нутаг дэвсгэрт орж ирсэн цагаас гаалийн бүрдүүлэлт хүртэлх үеийн турш, экспортын бүх бараа бүтээгдэхүүнүүд мэдүүлгээ өгсөн хугацаанаас нутаг дэвсгэрээс хөдлөх хүртэлх үеийн турш, бараа бүтээгдэхүүнийг бүх дамжин өнгөрүүлэлт, шилжүүлэн ачилтын үед нутаг дэвсгэрт орж ирсэн цагаас нутаг дэвсгэрээс хөдлөх хүртэлх үеийн турш гаалийн хяналтыг дагаж мөрдөнө.

18 дугаар зүйл.

Импортын бараа бүтээгдэхүүнүүдийг хүлээн авагч, экспортын бараа бүтээгдэхүүнүүдийг илгээгч нь импорт, экспортын лиценз, холбогдох баримт бичгийг гаалийн байгууллагад шалгуулахаар мэдүүлнэ. Импорт буюу экспортын лиценз байхгүй тохиолдолд, төрөөс импорт, экспорт хийх эрхийг нь хязгаарласан этгээдийн бараа бүтээгдэхүүнийг гаргахгүй. Ийм асуудлыг шийдвэрлэх тусгай арга хэмжээг Төрийн зөвлөл хуульчлан тогтооно. Импортын барааны хүлээн авагч нь мэдүүлгийг, тээврийн хэрэгсэл ирэх мэдүүлгээс хойш 14 хоногийн дотор гаалийн байгууллагад хүргүүлнэ, Гаалийн байгууллагаас өөрөөр тусгайлан зөвшөөрөөгүй бол экспортын барааны мэдүүлгийг ачуулахын өмнө 24 цагийн өмнө захиалагч нь хүргүүлнэ. Хүлээн авагч нь импортын бараа бүтээгдэхүүний мэдүүлгийг өмнөх хэсэгт тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд гаалийн байгууллага хугацаа хоцорсон мэдүүлгэд торгууль ногдуулна.

19 дүгээр зүйл.

Импорт, экспортын бүх бараа бүтээгдэхүүнийг гаалийн шалгалтанд хамруулна. . Шалгалтыг хийж байх үед импортолж буй бараа бүтээгдэхүүний хүлээн авагч, эсхүл экспортын бараа бүтээгдэхүүний илгээгч нь байх бөгөөд барааг хөдөлгөх , баглаа боодлыг нээх , дахин баглах ажлыг хариуцна. Гаалийн байгууллага нь шаардлагатай гэж үзвэл хүлээн авагч, эсхүл илгээгчийн оролцоогүйгээр барааг шалгах, дахин шалгалт авах буюу дээж авах эрхтэй. Хэрэв хүлээн авагч болон илгээгч тал нь хүсэлт гаргаад Гаалийн ерөнхий газар зөвшөөрсөн тохиолдолд импорт, экспортын барааг шалгалтаас чөлөөлж болно.

20 дугаар зүйл.

Импорт, экспортын бараа бүтээгдэхүүн нь гаалийн байгууллагаар тусгай зөвшөөрөл олгогдоогүй бол зөвхөн гаалийн төлбөр төлсөний дараа эсвэл гаалийн баталгаа гарсны дараа чөлөөлөгдөнө.

21 дүгээр зүйл.

Хэрэв импортын бараа бүтээгдэхүүний илгээгч нь Тээврийн хэрэгслийг хүлээн авсан тухай мэдэгдэл авснаас хойш гурван сарын дотор ачаа бараагаа гаалийн байгууллагад мэдүүлэхгүй бол гаалийн байгууллага тухайн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулж болно. Барааг тээвэрлэх, ачих, буулгах, хадгалах, татвар, хураамжийг барааг худалдаж олсон орлогоос суутгана, дараа нь үлдсэн дүнг илгээгч нэг жилийн дотор гаалийн байгууллагад өргөдөл гаргасан тохиолдолд буцаан олгоно. Хэрэв тогтоосон хугацаанд хэн ч өргөдөл гаргаагүй бол тухайн мөнгийг төрийн санд шилжүүлнэ. Хилээр нэвтрүүлж буй бараа бүтээгдэхүүнийг гаалийн бүрдүүлэлтгүй буюу хугацаа хэтэрсэн гэж Гаалийн байгууллагаас тогтоовол ачааны газарт буцаан илгээх буюу зөвшөөрсөн 3 сарын хугацаанд барааг тээвэрлэх, шилжүүлэхэд шаардлагатай тээврийн хэрэгслийн хүлээн авагч эсвэл илгээгч тал нь хариуцан гаргах барааг гаалийн байгууллагын хариуцсан этгээдийн шаардлагыг биелүүлсэний дараа буцаан авч болно. Шаардлагатай гэж үзвэл, Гаалийн байгууллагын зөвшөөрлөөр тогтоосон хугацааг 3 сараар сунгаж болно. Тогтоосон хугацаанд дуусгаагүй тохиолдолд өмнөх хэсэгт заасны дагуу Гаалийн байгууллага бараа бүтээгдэхүүнийг устгана. Хэрэв бараа бүтээгдэхүүнийг өмнө дурьдсан хугацаанаас удаан хугацаагаар хадгалах боломжгүй бол тогтоосон хугацаанд хүрэхээс өмнө гаалийн байгууллага тусгай нөхцөл байдалд устгалд оруулна. Импортын барааг эзэмшигч болон хүлээн авагч нь аваагүй тохиолдолд гаалийн байгууллага зарж борлуулна. Тээвэрлэлт, ачилт буулгалт болон хадгалалтын зардлыг төрийн санд оруулах мөнгөнөөс хасна.

22 дугаар зүйл.

Гаалийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр түр хугацаагаар импортолсон, эсхүл экспортолсон барааг 6 сарын дотор нутаг дэвсгэрт оруулж болон гаргаж болно. Тусгай нөхцөлөөр гаалийн байгууллагын зөвшөөрлөөр хугацааг сунгаж болно.

23 дугаар зүйл.

Гаалийн баталгаат агуулахад хадгалагдаж байгаа барааг хадгалах, боловсруулах, угсрах, нийлүүлэх үйл ажиллагааг гаалийн байгууллагад бүртгүүлж зөвшөөрөл авна.

24 дүгээр зүйл.

Импортын бараа бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлт хийхдээ хүлээн авагч тухайн барааг оруулж ирсэн нутаг дэвсгэрийн газарт гаалийн байгууллагад ; экспортолж буй бараа бүтээгдэхүүнийг гаалийн байгууллагад тухайн нутаг дэвсгэрээс гаргаж байгаа гаалийн байгууллагад илгээгч тал бүрдүүлж өгнө. Илгээгч, хүлээн авагч тал нь хүсэлт гаргаж, гаалийн байгууллагаас зөвшөөрсөн тохиолдолд импортын бараа бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийг хүлээлгэн өгөх газарт нь буюу гаалийн

байгууллага байгаа газарт, экспортолж буй бараа бүтээгдэхүүнийг гаалийн байгууллага байгаа ачааны газарт хийж болно. Ийм бараа бүтээгдэхүүнийг гаалийн байгууллагатай нэг газраас нөгөө рүү тээвэрлэхдээ гаалийн хяналтын шаардлагад нийцүүлсэн байна. Шаардлагатай бол гаалийн байгууллагын ажилтнууд нь барааг тээвэрлэлтийн үед дагалдаж явж болно. Бараа бүтээгдэхүүнийг, цахилгаан дамжуулах шугам, шугам хоолой болон бусад тусгай зориулалтын хэрэгслийг ашиглан нутаг дэвсгэрт оруулах буюу гаргахдаа тухайн Зохицуулалтын нэгж байгууллагууд нь тогтмол үеүүдэд гаалийн байгууллагад тогтмол тайлагнаж, шаардлагатай бол гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

25 дугаар зүйл.

Бүх дамжин өнгөрөх, шилжүүлэн ачих, ачуулах бараа бүтээгдэхүүний талаар, тээврийн хэрэгслийг хариуцаж буй этгээд нь бараа бүтээгдэхүүн нутаг дэвсгэрт нэвтэрч буй газрын гаалийн байгууллагад үнэн зөвөөр мэдүүлэх бөгөөд тогтоосон хугацаанд нутаг дэвсгэрээс буцаан тээвэрлэнэ. Гаалийн байгууллага нь шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалт хийнэ.

26 дугаар зүйл.

Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр нэгж, хувь хүн гаалийн хяналтын дор байгаа барааг барьцаалах, шилжүүлэх, хүргэх, шилжүүлэх, өөрчлөх, дахин баглах, шилжүүлэх болон барааны таних тэмдгийг өөрчлөх эрхгүй. Гаалийн битүүмжлэлийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй хүн эвдэж, нээж болохгүй. Гаалийн хяналтад байгаа бараа бүтээгдэхүүнийг хадгалж байгаа газар болон агуулахын ажилтнууд гаалийн дүрэмд заасны дагуу барааг хүлээн авах, хүргэх журмыг биелүүлэх ёстой. Гаалийн хяналтын бүсээс гаднах, гаалийн хяналтад байгаа бараа бүтээгдэхүүний агуулах байр нь Гаалийн байгууллагаас зөвшөөрөгдсөн байх ёстой бөгөөд гаалийн хяналтыг дагаж мөрдөнө.

27 дугаар зүйл.

Гаалийн ерөнхий газар нь Төрийн зөвлөлийн харьяа холбогдох салбаруудтай хамтарч,болон бие даан хилээр нэвтрүүлж, гаргаж буй агуулах савнуудад тавих хяналтын журам; хилээр нэвтэрч, гарч буй барааг болон живсэн хөлөг онгоцыг аврах хяналтын журам; жижиг хэмжээний хилийн гүйлгээнд оролцсон хилээр нэвтрүүлж гаргаж буй бараа бүтээгдэхүүний хяналтын журам болон энэ хуульд заагаагүй бусад хилээр нэвтрүүлж, гаргаж буй бараа бүтээгдэхүүнүүдийн журмуудыг гаргана.

Дөрөвдүгээр бүлэг. Гаалийн хилээр бараа нэвтрүүлэх, гаргах

28 дугаар зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй хувь хүний ачаа тээш болон шуудангаар илгээсэн бараа нь гаалийн хяналтын дагуу хувийн хэрэглээний зориулалтаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэх ёсгүй.

29 дүгээр зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй барааг эзэмшигч нь Гаальд үнэн зөвөөр мэдүүлж, гаалийн шалгалтад оруулна. Гаалийн битүүмжлэлийг зөвшөөрөлгүй хүн эвдэж, нээхийг хориглоно.

30 дугаар зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй шуудангийн илгээмжийн ачих, буулгах, шилжүүлэн ачих, дамжин өнгөрөх нь гаалийн хяналт дор явагдах бөгөөд илгээж буй шуудангийн аж ахуйн нэгж нь дагалдах бичиг баримтыг Гаальд мэдүүлнэ. Шуудангийн аж ахуйн нэгж нь олон улсын илгээмжийг нээх, битүүмжлэх хуваарийг Гаальд урьдчилан мэдэгдэнэ. Гаалиас газар дээр нь хяналт, шалгалтыг хийлгэхээр ажилтнуудыг илгээнэ.

31 дүгээр зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй шуудангаар илгээсэн барааг Гаалийн шалгалтад оруулсны дараа зохицуулах нэгжүүдээс илгээж хүргэнэ.

32 дугаар зүйл.

Гаалийн байгууллагаас татваргүйгээр нутаг дэвсгэрт түр оруулах, гаргахыг зөвшөөрч бүртгэсэн барааг эзэмшигч нь л нутаг дэвсгэрт буцаан авчирч, оруулж ирж болно. Нутаг дэвсгэрээр дамжин гарч буй этгээд нь авч явж буй бараагаа гаалийн баталгаагүйгээр нутаг дэвсгэрт үлдээж болохгүй.

33 дугаар зүйл.

Энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу, эзэмшигч нь орхин явсан хилээр нэвтрүүлж, гаргаж буй барааг; хэн ч нэхэмжлэл гаргаагүй буюу гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй бараа; хүргэж буюу буцаан олгож болохгүй хилээр нэвтрүүлсэн шуудангийн зүйлсийг гаалийн байгууллага устгана.

34 дүгээр зүйл.

Дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа гадаадын төлөөлөгчид, ажилчдын албан хэрэгцээний болон хувийн зориулалттай хилээр нэвтрүүлж, гаргаж буй бараа нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Дипломат эрх ямба, дархан эрхийн тухай дүрмүүдийн дагуу зохицуулагдана.

Бүлэг 5 Гаалийн татвар

35 дугаар зүйл.

Энэ хуульд өөрөөр заагаагүй бол, гаалийн татварыг экспортолж, импортлохоор зөвшөөрөгдсөн буюу нутаг дэвсгэрт оруулах, гаргах зөвшөөрөлтэй бараа бүтээгдэхүүний экспорт, импортын тарифт үндэслэн ногдуулна. Тарифын мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

36 дугаар зүйл.

Импортын бараа бүтээгдэхүүний хүлээн авагч, экспортын бараа бүтээгдэхүүний илгээгч болон хилээр нэвтрүүлж, гаргаж буй барааны эзэмшигч нь гаалийн татвар төлөгч байх үүргийг хүлээнэ.

37 дугаар зүйл.

Импорт, экспортын бараа бүтээгдэхүүний гаалийн татвар төлөгч нь татварын санамж бичиг гарсан хугацаанаас хойш 7 өдрийн дотор тогтоосон дүнгээр төлнө. Энэ хугацаанд төлөөгүй тохиолдолд, Гаалиас хүлээгдсэн төлбөр төлөлтийн хураамжийг ногдуулна. Гаалийн татвар нь гурван сараас дээш хугацаагаар төлөгдөөгүй хэтэрсэн тохиолдолд, Гаалиас батлан даагчаар татварыг төлүүлэх, буюу бараа бүтээгдэхүүнийг худалдаалж татварыг нөхөн төлөхөөр зааж болно. Гаалиас шаардлагатай гэж үзвэл, батлан даагчийн буюу гаалийн татвар төлөгчийн банкинд байршуулсан мөнгөнөөс төлөх татварын хэмжээг суутгах талаар банкинд мэдээлнэ. Гаалийн татвар төлөгч нь хилээр нэвтрүүлж, гаргаж буй барааны татварыг барааг гаргахаас өмнө төлсөн байна.

38 дугаар зүйл.

Импортын барааны төлөх татварын үнэ нь Гаалийн байгууллагаас зөвшөөрсөн, ердийн тээврийн болон даатгалын зардал байна, /CIF price/ экспортын барааны төлөх татварын үнэ нь Гаалийн байгууллагаас зөвшөөрсөн ердийн /FOB price/-аас экспортын татварыг хассан байна. Тээврийн болон даатгалын зардал, FOB price – ийг тодорхойлох боломжтой үед, Гаалийн байгууллагаас экспорт, импортын барааны төлөх татварын үнийг тогтооно. Хилээр нэвтрүүлж, гаргаж буй зүйлсийн төлөх татварын үнийг Гаалийн байгууллагаас тогтооно.

39 дүгээр зүйл.

Хилээр нэвтрүүлж, гаргаж буй дараах импорт, экспортын бараа бүтээгдэхүүн болон барааны татварыг хөнгөлөх буюу чөлөөлнө:

- I. Арилжааны ашиг олох зорилгогүй сурталчилгааны зүйлүүд болон худалдааны дээж бүтээгдэхүүнүүд,
- II. Гадаадын засгийн газруудаас буюу олон улсын байгууллагуудаас үнэ төлбөргүйгээр бэлэглэсэн материалууд,
- III. Гаалийн байгууллагаас гарахын өмнө эвдрэл, хохирол учирсан бараанууд,
- IV. Тогтоосон хязгаарын доторх хэмжээ, үнэ бүхий бараанууд,
- V. Татвараас хөнгөлөх, чөлөөлөхөөр хуулиар тодорхойлсон бусад бараа бүтээгдэхүүнүүд болон,
- VI. Бүгд Найрамдах Хятад ард Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүдэд татвараас хөнгөлөх чөлөөлөхөөр тодорхойлсон бараа бүтээгдэхүүнүүд,

40 дүгээр зүйл.

Чөлөөт бүсийн болон бусад тусгайлан заасан газруудын импорт, экспортын барааны татварыг хөнгөлөх буюу чөлөөлж болох бөгөөд, Хятад-гадаадын өмчийн хамтарсан үйлдвэрүүд зэрэг онцгой аж ахуйн нэгжүүд, Хятад-гадаадын гэрээт үйлдвэрүүд болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн импорт, экспортын бараа бүтээгдэхүүнд, тусгай зориулалтын импорт, экспортын бараа бүтээгдэхүүнд болон нийтийн халамжийн үйл ажиллагаануудад хандивласан материалууд зэргийг хамааруулна. Уг хөнгөлөлт, чөлөөлөлтийн хамрах хүрээг Төрийн зөвлөлөөс тодорхойлж, дүрэм журмыг боловсруулна. Төрийн зөвлөл буюу Төрийн зөвлөлөөс эрх мэдэл олгосон салбарууд нь хамрах хүрээг тодорхойлж, жижиг хэмжээний хилийн наймааны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүрэм журмыг боловсруулна.

41 дүгээр зүйл.

Өмнөх зүйлд заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэсэн импортын бараа бүтээгдэхүүнүүд нь зөвхөн тусгайлан заасан газрууд болон аж ахуйн нэгжүүдэд эсхүл тусгай зориулалтаар л ашиглагдаж болно. Гаалийн байгууллагын баталгаа аваагүй болон зохих ёсоор татвар төлөөгүй бол тэдгээрийг ашиглаж болохгүй.

42 дугаар зүйл.

Энэ хуулийн 39, 40 дүгээр зүйлд зааснаас бусад түр хугацааны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг Гаалийн ерөнхий газраас дангаар буюу Төрийн зөвлөлийн харьяа санхүүгийн салбартай хамтран Төрийн зөвлөлөөс тогтоосон дүрэм журмын дагуу хянан шалгаж, баталгаажуулна.

43 дугаар зүйл.

Гаалийн байгууллагаас түр хугацаагаар экспортолж импортлохоор баталсан бараа бүтээгдэхүүнд болон гаалийн баталгаат агуулахад хадгалагдаж байгаа барааг тусгай зөвшөөрлөөр импортлоход, бараа бүтээгдэхүүн хүлээн авагч буюу илгээгч нь Гаалийн байгууллагад мэдүүлж, татвартай тэнцэх хэмжээний баталгаа гаргах буюу байршуулсны дараа түр хугацааны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгож болно.

44 дүгээр зүйл.

Гаалийн байгууллагаас импорт, экспортын бараа бүтээгдэхүүн болон хилээр нэвтрүүлж, гаргаж буй барааг гаргасны дараа оногдуулсан татвар төлөгдөөгүй эсвэл дутуу төлөгдсөнийг олж тогтоовол, Гаалийн байгууллага нь үүрэгт гаалийн татвар төлөгчөөс төлөх боломжтой мөнгийг өмнөх татвар төлөлт болон барааг гаргаснаас хойш нэг жилийн дотор хураан авна. Хэрэв оногдуулсан татварыг төлөөгүй үйлдэл нь Гаалийн байгууллагын дүрэм журмын зөрчиж байвал, Гаалийн байгууллага нь төлөгдөөгүй мөнгөн дүнг 3 жилийн дотор хураан авна.

45 дугаар зүйл.

Гаалийн байгууллагаас татвар төлөгч татварыг илүү дүнгээр төлснийг олж мэдвэл, тэр даруй мөнгийг буцаан олгоно. Гаалийн татвар төлөгч нь Гаалийн байгууллагаас гаалийн татвар төлсөн өдрөөс хойш нэг жилийн дотор буцаан олгохыг шаардах эрхтэй.

46 дугаар зүйл.

Гаалийн байгууллагатай татвар төлөлттэй холбоотойгоор үүссэн маргаанд гаалийн татвар төлөгч нь холбогдвол, татварын санамж бичиг гарснаас 30 хоногийн дотор, хэргийг дахин хянуулахаар Гаалийн байгууллагад бичгээр өргөдөл гаргана. Гаалийн байгууллага нь өргөдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шийдвэр гаргана. Уг шийдвэрийг гаалийн татвар төлөгч нь хүлээн авахаас татгалзвал, Гаалийн ерөнхий газарт шийдвэрийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэргийг дахин хянуулахаар өргөдөл гаргаж болно. Гаалийн ерөнхий газраас гаргасан шийдвэрийг мөн хүлээн авах боломжгүй гэж үзвэл, шийдвэрийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Бүлэг 6 Хууль зүйн хариуцлага

47 дугаар зүйл.

Гаалийн хяналтаас зугтсан дор дурьдсан үйлдлүүдийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт тооцно:

- i. Төрөөс экспортолж, импортлохыг хориглосон хүйтэн зэвсэг, хуурамч мөнгөн тэмдэгтүүд болон нутаг дэвсгэрт оруулах эсвэл гаргахаар мансууруулах эм бодис зөөвөрлөх, авч явах болон шуудангаар илгээх; нутаг дэвсгэрт оруулах эсвэл гаргахаар ашгийн төлөө зорилгоор буюу түгээх зорилгоор садар самуунтай холбоотой эд зүйлсийг зөөвөрлөх, авч явах болон шуудангаар илгээх; соёлын дурсгалт зүйлсийг нутаг дэвсгэрээс гаргахаар зөөвөрлөх, авч явах болон шуудангаар илгээх;
- ii. Төрөөс экспортолж, импортлохыг хориглосон энэ зүйлийн (i) дэх хэсэгт оруулаагүй барааг ашгийн төлөө зорилгоор их хэмжээгээр эсвэл өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг нутаг дэвсгэрт оруулах буюу гаргахаар зөөвөрлөх, авч явах болон шуудангаар илгээх; төрөөс импорт, экспорт хийх эрхийг нь хязгаарласан этгээдийн буюу хуулийн дагуу цуглуулах гаалийн татвартай хамааралтай бараа бүтээгдэхүүнийг их хэмжээгээр болон өндөр үнээр гаргах,
- iii. Гаалийн баталгаа болон татвар төлөлтөө хийлгүйгээр төрөөс их хэмжээний болон өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тусгай жагсаалт дахь тусгай зөвшөөрлөөр импортлосон гаалийн баталгаат агуулахад хадгалагдаж байгаа барааг худалдаалах,

Хууль бусаар хил дамжуулсан бараа бүтээгдэхүүний үнэ, хэмжээ нь ямар ч байсан гаалийн хяналтад эсэргүүцэл үзүүлсэн, зэвсэглэсэн буюу хүч хэрэглэсэн бол хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт тооцно. Ардын шүүхээс хууль бусаар барааг хил нэвтрүүлсэн гэм буруутай этгээдэд хууль бусаар хил нэвтрүүлсэн бараа бүтээгдэхүүнийг хураах болон торгууль ногдуулах эрүүгийн шийтгэл хүлээлгэнэ.

48 дугаар зүйл

49 дүгээр зүйл

Дараах хил дамжуулан худалдах үйлдлүүд нь гэмт хэргийн шинжтэй бол энэ хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу шийтгэл хүлээлгэнэ:

1. Төрөөс импортлохыг хориглосон барааг хууль бус худалдаа эрхлэгчдээс шууд болон хууль бусаар нийлүүлсэн, их хэмжээний болон өндөр үнэтэй бүтээгдэхүүн, хууль бусаар худалдаж авсан барааг хууль бус худалдаа эрхлэгчдээс шууд болон хууль бусаар нийлүүлсэн,

2. Төрөөс импортлох болон экспортлохыг хориглосон улсын дотоодод байгаа бүтээгдэхүүн болон усан замаар тээвэрлэх барааг худалдсан, борлуулсан, тээвэрлэсэн эсвэл хуулийн дагуу олгосон гэрчилгээгүй бараа бүтээгдэхүүн, төрөөс импорт, экспорт хийх эрхийг нь хязгаарласан этгээдийн олон тооны болон өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг тээвэрлэсэн, худалдсан, борлуулсан
Дээрх үйлдлүүлийг хийсэн нь хил дамжуулан худалдах гэмт хэргийн шинжийг агуулаагүй бол энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50 дугаар зүйл

Хувь хүний ачаа тээшинд болон шуудангаар хувийн хэрэгцээний барааг илгээхдээ нутаг дэвсгэрийн харьяаллын гадна болон тогтоосон хэмжээнээс их хэмжээний бараа авч явах, энэ талаар Гаалийн байгууллагад мэдэгдээгүй бол төлбөрийг төлүүлж торгуул ногдуулна .

51 дүгээр зүйл

Энэ хуульд заасан Гаалийн хяналтын хэм хэмжээг зөрчсөн дараах үйлдлүүдэд торгуулийн арга хэмжээ ногдуулна.

1. Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр нутаг дэвсгэрт нэвтрэх болон гарах тээвэрлэлт хийсэн,
2. Тээвэрлэж буй зүйлийнхээ хэзээ ирэх, буцахыг Гаалийн байгууллагад мэдэгдэхгүй байх, мөн түүнийгээ хаана байрлуулах болон хаашаа зөөх, зөөвөрлөлтийн талаар мэдэгдэхгүй байх,
3. Гаалийн байгууллагад импорт, экспортын талаар үнэн зөвөөр мэдэгдэхгүй байх,
4. Холбогдох журмуудаар хүлээн зөвшөөрөгдөөгүй ба бараа бүтээгдэхүүнийг шалгаж хилээр нэвтрүүлэх болон гаргахад хийгддэг хяналт шалгалтыг даваагүй,
5. Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бараа бүтээгдэхүүнийг буулгасан эсвэл буулгаагүй болон зөвшөөрөлгүйгээр зорчигчдыг тээврийн хэрэгслээс буулгасан эсвэл бүүлгаагүй,
6. Гаалийн байгууллагын шаардлагаар хилээр нэвтрүүлэх болон гаргах тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй гаргасан,
7. Гаалийн байгууллагын зөвшөөрлөөр хилээр нэвтрүүлэх болон гаргах тээвэрлэлтийн чиглэлийг нэг газраас нөгөөд шилжүүлэх буюу газар нутаг дамжуулан Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн,
8. Хилээр нэвтрүүлэх болон гаргах тээвэрлэлтийг Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тухайн нутаг дэвсгэрт ганцаар эсвэл хамтаар хэрэгжүүлсэн,
9. Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөлөг онгоц эсвэл нисдэг онгоцыг давагдашгүй хүчин зүйлийн улмаас тухайн нутаг дэвсгэрт зогсоосон

эсвэл газардуулсан, ойр байгаа Гаалийн эрх бүхий байгууллагад хууль бус бараа бүтээгдэхүүний талаар гомдол гаргаагүй, тухайн барааг нутгаасаа гаргаагүй,

10. Гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр гаалийн байгууллагын хяналтанд байдаг барааг онгойлгосон, авсан, хүргэсэн, дамжуулсан, өөрчилсөн, дахин савласан, зээлдсэн болон шилжүүлсэн,
11. Зөвшөөрөлгүйгээр гаалийн байгууллагаас тависан лацыг онгойлгосон эсвэл эвдэлсэн,
12. Гаалийн хяналттай холбоотой энэ хуульд заасан зохицуулалтыг зөрчин гаалийн хяналт хийж чадаагүй бол Гаалийн байгууллага хилээр бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, тээвэрлэхэд тавих хяналтыг түр зогсооно,

52 дугаар зүйл

Хууль бусаар хил давуулан худалдаалж байгаа бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, хууль бус орлогыг хураан авч шүүхийн тогтоолоор торгууль оногдуулах ба хууль бус бараа, хууль бус орлогод оногдуулсан гаалийн торгуулийн орлогыг төрийн санд шилжүүлнэ. Гаалийн байгууллага нь хууль бус бараа бүтээгдэхүүн хилээр нэвтрүүлэх болон гаргах, хууль бус орлог043Ед хяналт тавьж ажиллах үүрэгтэй ба ардын шүүхийн шийдвэр болон гаалийн байгууллагын шийдвэрийг үндэслэн хууль бус орлогыг хураан авч Төрийн зөвлөлийн зохицуулалтын дор төрийн санд шилжүүлэх үүрэгтэй.

53 дугаар зүйл

Хэрэв холбогдох тал нь гаалийн шийтгэлийн шийдвэрт хамаатай бол, тухайн шийдвэр гаргасан гаалийн байгууллага болон дээд шатны байгууллагад тохиолдлыг дахин хянуулахаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өргөдөл гаргах эрхтэй, шийтгэх тухай нийтэд мэдээлсэнээс хойш өргөдөл гаргах боломжгүй. Хэрэв тухайн тал дахин хэлэлцүүлгийн дараа шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй хэвээр байгаа бол шийдвэрийг хүлээн авсанаас 30 хоногийн дотор эсвэл нийтэд мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Ардын шүүхэд гомдол гаргаж болно. Хэрэв тухайн тал гаалийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, дээр дурьдсан хугацаанд хэргийг дахин хянан үзүүлэхгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргахгүй бол гаалиас тухайн талыг баривчлах шийтгэлийн оронд хөрөнгийг хураан авч, бараа бүтээгдэхүүнийг нь борлуулах ба Ардын шүүхээс тухайн шийтгэл зайлшгүй эсэхийг тодруулна.

54 дүгээр зүйл

Гаалийн байгууллага хилээр бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх болон гаргахаар хяналт шалгалт хийх явцдаа хохирол учруулсан бол хохирлыг барагдуулна.

55 дугаар зүйл

Хууль бус барааг хураан авсан гаалийн ажилтан барааг хувьдаазавшсан бол БНХАУ-ын Эрүүгийн хуулын 155 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэнэ. Ямар ч гаалийн ажилтан хууль бус бараа бүтээгдэхүүнийг зарах эрхгүй ба хэрэв зарсан бол буцаан өгөх үүрэгтэйгээс гадна уг ажилтанд сахилгын шийтгэл ногдуулна.

56 дугаар зүйл

Гаалийн ажилтан албан эрх мэдлээ урвуулан ашиглан хяналт шалгалтын процессыг хойшлуулсан бол түүнд сахилгын шийтгэл ногдуулна . Хувийн ашиг сонирхлынхоо тулд үүргээ зөрчин дээрх хууль бус үйлдлийг үйлдсэн этгээдэд сахилгын шийтгэл ногдуулахаас гадна онцгой тохиолдолд энэ хуульд заасны дагуу эрүүгийн гэмт хэрэгт сэжигтнээр татаж болно.

Долдугаар бүлэг. Нэмэлт заалт

57 дугаар зүйл.

Энэ хуульд дараах нэр томъёог хэрэглэнэ:

Хилээр нэвтрүүлэх болон гаргах тээвэрлэх гэдэг нь хүн болон бараа бүтээгдэхүүнийг өөр өөр төрлийн буюу хөлөг онгоц, тээврийн хэрэгсэл, нисэх онгоц, ан амьтан ашиглан тухайн газар нутагт оруулах эсвэл гаргахыг ойлгоно.

Барааг дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих, барааг дамжуулах гэдэгт тухайн нутаг дэвсгэрийн гадна байгаа барааг нутаг дэвсгэрээрээ нэвтрүүлж дахин нутаг дэвсгэрийнхээ гадна гаргах ба тодруулбал барааг дамжин өнгөрүүлэх гэдэгт дээрх үйлдлийг газраар дамжин өнгөрүүлэхийг, барааг шилжүүлэн ачих гэдэгт газраар дамжин өнгөрдөггүй боловч гаалийн газартай өөр хэлбэрээр тээвэрлэхийг, барааг дамжуулах гэдэгт авч ирсэн барааг адил хөлөг онгоц болон нисэх онгоцоор дахин нутаг дэвсгэрийн гадна гаргахыг тус тус ойлгоно. Гаалийн хяналтанд байгаа бараа гэдэгт нь энэ хуулийн 17 дугаар зүйлд заагдсан импортын болон экспортын бараа, дамжуулан өнгөрүүлэх бараа, шилжүүлэн ачих бараа ба дамжуулах бараа болон түр хугацааны импорт болон экспортын бараа, барьцаатай бараа, бусад хилээр нэвтрүүлэх болон гаргах гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй байгаа байрааг ойлгоно.

Барьцаатай бараа гэж гаалийн байгууллагын зөвшөөрлөөр нутаг дэвсгэрт орж ирсэн барааг нутаг дэвсгэрт хадгалж, боловсруулсан, угсарсаны дараа нутаг дэвсгэрээс гадагш гаргана гэсэн гаалийн бүрдүүлэлтэнд ямар ч албан ёсны зүйл хийгдээгүй зүйлсийг хэлнэ. Гаалийн ажиглалтын бүс гэдэг нь Төрийн зөвлөлөөс баталсан гаалийн байгууллага, гаалийн хяналт тавьдаг бусад газар, гаалийн хяналтгүй газар,

гаалийн байгууламжгүй аливаа далайн боомт, төмөр зам, авто зам, нисэх буудал, хилийн боомт, нутаг дэвсгэрт нэвтрэн, гарах цэгийг хэлнэ.

58 дугаар зүйл

Гаалийн байгууллага нь энэ хуулийг зөрчсөн этгээдийг олж илрүүлэх, хураахад хүргэж буй мэдээллийг өгсөн, туслалцаа үзүүлэхэд ач холбогдол бүхий үйлчилгээг өгсөн нэгж болон хувь хүнийг шагнаана. Тухайн нэгж болоод хувь хүний талаарх мэдээлэл нууцлалтай байна.

59 дүгээр зүйл

Төрийн зөвлөл нь чөлөөт бүсэд болон бусад газар нутгийн онцгой нутаг дэвсгэрболон нийт нутаг дэвсгэрт бараа бүтээгдэхүүний хяналт, тээвэрлэлтийн хяналтыг тогтооно.

60 дугаар зүйл

Гаалийн ерөнхий газар нь энэ хуулийн дагуу, хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төрийн зөвлөлд хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тайлагнаж зөвшөөрөл авна.

61 дүгээр зүйл

Энэ хууль нь 1987 оны 07 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болно. БНХАУ-ын Засгийн газраас 1951 оны 04 сарын 18-нд баталсан Гаалын түр хууль энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хүчингүй болно.